

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ГУЧИНГУРАВДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны арваннэгдүгээр сарын 19-ний 14 цаг 03 минутад эхэлж, 15 цаг 55 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 58 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Зарим удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах тухай</p> <ul style="list-style-type: none">- Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилуулахаар- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөрөнгө оруулалтын газрын даргын албан тушаалд томилуулахаар	<p>ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Гочоогийн Нарангэрэлийг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 19-ний</p>

		<p>өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Сэрээтэрийн Жавхланбаатарыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөрөнгө оруулалтын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай</p>	<p>ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:</p> <p>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтын ХЭГ/2149 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, сонгон шалгаруулалтыг 2015 оны 11 дүгээр сарын 20-ноос эхлэн, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд, нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>
3	<p>Хүний Эрхийн Үндэсний комиссын Гомдол, хяналт, шалгалтын хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Тогоохүүгийн Ихтамирыг Хүний эрхийн үндэсний комиссын Гомдол,</p>

		<p>хяналт шалгалтын хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Хүний эрхийн үндэсний комиссын Ажлын албаны дарга А.Дашдэлэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Зам тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: Бямба-Оюугийн Артурыг Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Зам, тээврийн яамны яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	<p>Барилга хот байгуулалтын яамны Төрийн захирганы удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: Миеэгомбын Болортуяаг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар</p>

		<p>дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	<p>Завхан, Говь-Алтай аймгийн нутгийн захиргааны байгууллагын болон УИХ-ын Тамгын газрын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p>	<p>ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 10 дугаар сарын 30, 11 дүгээр сарын 02, 03-ны өдрүүдэд Завхан аймаг, Говь-Алтай аймагт тус тус зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Завхан аймаг, Говь-Алтай аймагт 2015 оны 10 дугаар сарын 30, 11 дүгээр сарын 02, 03-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 39 иргэн /Завхан аймагт 12, Говь-Алтай аймагт 27/-ийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 106 иргэн /Завхан аймагт 28, Говь-Алтай аймагт 78/-ийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 5, 6</p>

дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 16 /Завхан аймагт 6, Говь-Алтай аймагт 10/-ийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 7, 8 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 30 иргэн /Завхан аймагт 5, Говь-Алтай аймагт 25/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх

3. Энэхүү тогтоолын 5-8 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 46 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Завхан аймаг дахь салбар зөвлөл /Д.Түвшинжаргал/-д, Төрийн албаны зөвлөлийн Говь-Алтай аймаг дахь салбар зөвлөл /П.Золжаргал/-д тус тус үүрэг болгох

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн

		<p>жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн Архивын сан хөмрөг, архив бичиг хэргийн асуудал хариуцсан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 3 иргэнийг “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 2 дугаар хавсралтад дурдсан нэг иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх.</p> <p>3. Нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилохыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатарт үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
7	Зарим хүмүүсийг "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах тухай	<p>ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Төрийн албаны зөвлөлийн 2013</p>

		<p>оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх санаачлагатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, тогтвортой амжилт гарган төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан дараах нэр бүхий төрийн 35 албан хаагчдыг Монгол Улсын "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах</p> <p>2. Шагнагдсан хүн тус бүрийн тэмдгийг дагалдах мөнгөн шагнал (хоёр зуун мянган төгрөг)-ыг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 4.2-т заасны дагуу шагнагдагсдад тухайн байгууллагаас олгох</p> <p>3. Шагнагдсан нийт төрийн албан хаагчдад баяр хүргэж, ажлын амжилт хүсэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
8	<p>Бусад асуудал / Засгийн газрын гишүүн, Дэд бүтцийн хөгжлийн дэд сайдаар 1996-1998 онд ажиллаж байсан Г.Нямдавааг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай/</p>	<p>ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Дэд бүтцийн хөгжлийн сайдаар 1996-1998 оны хооронд томилогдон ажиллаж байсан Галсандагвын Нямдавааг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн</p>

		ТОГТООЛ ГАРГАХААР ТОГТОВ.
--	--	---------------------------

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА